

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Л.ЭНХ-АМГАЛАН: АУДИТЫН ГАЗАР
ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАХИАЛГААР
ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭДЭГ

II нүүрт

ХЭН НЬ ХЭН БЭ

ӨӨРИЙН ГЭСЭН КАПИТАЛТАЙ
Ц.МӨНХ-ОРГИЛ

V нүүрт

ЧУХАЛ СЭДЭВ



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Дугаарын **60** мөр
Төрийн
залгамж чанар
хаачив

Хий боргодог “НОХОЙ”

Н.ПУНЦАГБОЛД

МАН 2016 оны сонгуулиар Мүнэмлэхүй ялалт байгуулж, 65 суудалтай болсон. Тиймээс дангаар бүх шийдвэрийг гаргаж, даналзах эрх нь тэдэнд бий. Гэвч МАН сүүлийн 2-3 сар ердөө л хий боргодог “нохой” аятай л байлаа. Баахан мэдэгдэл гаргаад л, түүнийг ч хасна, үүнийг ч танана. Хэт өндөр цалинтай дарга нарын түрийвчээ түнтийлдэг мөнгөний багахан хувийг нь улсад үлдэнэ. Төсөв хэмнэнэ, утас, унааны мөнгийг хасна гээд л байсан. Сүүлдээ татвар нэмж эдийн засгаа аврах арга хайж үзлээ. Оюутны 70-ыг байхгүй болгоно, автобусаар дураараа зорчдог байдлыг нь болуулна. Хүүхдийн мөнгийг яг зорилтот хэсэг нь олгоно гэсэн. Гэр

бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зэрэг багц хуулийг буцааж татахаар болсон. Гэх мэт маш олон зоригтой алхмуудыг хийхээр болж, “боргож” эхэлсэн нь саяхан. Гэвч өнөөдөр тэднээс аль нь биеллээ олов. Хий боргож боргож хазаж чадалгүй л үлдлээ. Уг нь ганц хоёр ч болов хазчихсан бол зүгээр байсан юм. Харамсалтай нь урьдын л адил ард түмэнд таалагдах гэж хичээдэг арчаагүй аргаа өөрчилсөнгүй. МАН өнгөрсөн 20 гаруй жилийн хугацааны ихэнхэд нь төр барьсан. Тэр хугацаандаа дараагийн сонгуулиар яаж ард түмэнд таалагдсан хэвээрээ үлдэх вэ гэдэг “мөрийн хөтөлбөр”-ийг л хэрэгжүүлж ирсэн.

Үргэлжлэл нь III нүүрт



Төгсгөл нь III нүүрт

Б.БААТАРЦОГТ:
ЭРДЭС, БАЯЛГИЙН САЛБАРТ
ХУВИЙН ХЭВШИЛ,
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ГЭЖ
ЯЛГАВАРЛАЖ БОЛОХГҮЙ

Дэлгэрэнгүй ярилцлагыг VI-VII нүүрнээс



ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ

INSPIRON 5000 SERIES



БИД ТАНЫ АЖЛЫГ ХӨНГӨВЧИЛНӨ

Inspiron 15 5000 загварын нөүтбүүкүүд нь таны хэрэгцээнд тохируулсан Full HD дэлгэц, гайхалтай график үзүүлэлт, Intel® Core i5 процессортой учир таны төсөөлснөөс ч илүүг бүтээж чадна.

Онцгой урамшуулал

Dell брэндийн нөүтбүүк худалдан аваад Targus брэндийн үүргэвчийг бэлгэнд аваарай.



Бэлгэнд

- Үүргэвч
- 2 жилийн баталгаа
- McAfee вирусн програм

www.facebook.com/PCmallOfficial
www.instagram.com/PCmall_Official

Биднийг дагаарай 7575-3535

Хаяг: PC Mall төв: Их сургуулийн гудамж 31/1, Ш/Х: 346, Улаанбаатар - 14193, Сүхбаатар дүүрэг - 8

ХААН банк	Авах			Зарах			Хуудалгаа хөгжлийн банк	Авах			Зарах		
	АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ФУНТ	РУБЛЬ	ЮАНЬ		АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ФУНТ	РУБЛЬ	ЮАНЬ
	2208.00	2459.00	21.51	2233.00	2531.00	22.19		2200.00	2447.00	21.39	2230.00	2528.00	22.17
				2915.00	32.90	330.50					2919.00	32.96	328.00
				3021.00	35.90	334.30					3013.00	35.71	334.80

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

ҮЗЭЛ БОДОЛ

Хий боргодог “ХОХОЙ”

Дугаарын **60** мөр
Төрийн
залгамж чанар
хаачив

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Одоо ч бас тэгэх гэж байна. Өнгөрсөн дөрвөн жилд хотыг удирдсан нөхдүүд дугаарын хязгаарлалтаас авахуулаад маш олон зүйлийг зоригтой хийсэн. Угаасаа зориглохгүй бол болохгүй байсан юм. Гэтэл МАН-ынхан “Уг нь бид дугаарын хязгаарлалт хийх гэж байсан. Судалж, санаачилгыг нь гаргасан. Яг хийх гэж байтал сонгууль болчихсон. АН-ынхан бидний санааг л хэрэгжүүлсэн төдий” гэх маягийн юм яриад сууж байж билээ. Яг үнэн хэрэг дээрээ тэд дугаарын хязгаарлалт хийхээр ард түмэнд таалагдахгүй гэж бодоод л хийгээгүй гээд хэлчихэд нэг их буруудсан болохгүй байх. Одоо ч гэсэн яг ийм л байдлаар асуудалд хандаж байна. Тэд ерөөсөө иргэд юу гэхийг л харж байгаа. Иргэд ч гэж дээ, социал ертөнцөд идэвхтэй байгаа цөөн хэдэн хүний л санаа бодлыг давж гарахгүй байна. Уг нь МАН-ынхан зарим “хазалт”-аа зоригтойхон шиг хийчих байсан юм. Тэгсэн бол ард түмэнд илүү их таалагдах байлаа.

Тухайлбал, цалинурамшуулал нь “тасарцан” Төрийн өмчит компанийн дарга нарынхаа мөнгийг жаахан танаачих хэрэгтэй байлаа. Ер нь тэдний цалинг хасахыг эсэргүүцсэн хүн байгаа юм уу. Хассан бол МАН гоёо харагдах байлаа. Сайд, дарга нарын утасны мөнгө, унааны зардлыг хасч, танана гэхэд хэн эсэргүүцсэн юм. Хэн ч эсэргүүцээгүй. Харин татвар нэмэх гэж байгааг, хүүхдийн мөнгийг хасч буйг, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийг



...Улстөрчид улс орон, эдийн засгаараа байнга тоглож байсны гай одоо тулж ирчихээд байна. Тэд тоглоомоо яаралтай зогсоохгүй бол улс сүйрлээ. Тийм болохоор одоо улс орноо өөд татах ажил хийх ёстой болохоос биш хий боргож, өнгөрснөө мууллаа гээд хэн ч бидний эдийн засгийг өөд нь татаад өгөхгүй...

буцааж татсаныг л эсэргүүцсэн. Хамтын тэтгэврийн хуулиар оролдож, ахмадуудаа

доромжилж байгааг л буруу гэсэн байх. Гэтэл МАН-ынхан орон нутгийн сонгууль болох үед намын нэр хүнд уналаа хэмээн арчаагүйтэж хэлсэн, ярьсанаасаа буцчихлаа. Алийг нь хэрэгжүүлээд, алийг нь боливол ард түмэнд таалагдах бол гэдгээ ч ялгаж байгаа юм алга. Албан тушаалын наймааны хэрэгсэл болгосон дэд сайдын суудлаа алга болгочихсон бол бүр гоёо харагдах байв. Ард түмэн босч алга таших байсан нь гарцаагүй.

Яам, тамгын газрын дарга нарын утасны мөнгө, шатахууны зардлыг хассан бол, тэгж хэмнэлт хийсэн бол иргэдэд таалагдах байлаа. Гэтэл чадсангүй. Оюутны 70 мянгыг хасна гэснээрээ зориглоод л хасчих байлаа. Манай улс мөнгөтэй, боломжтой үедээ оюутнуудаа тэтгэлэг өгч л байсан биз. Одоо мөнгө байхгүй, эдийн засаг хүндэрчихсэн үед хасаа л биз дээ. Энэ чинь л зоригтой шийдвэр. Зөв алхам.

Гэтэл бас л бүгдэд таалагдахын тулд энэ тэтгэлгийг байхгүй болгочихож чадсангүй. Бүр жилд нэг удаа олгохоор болж, хэмжээг нь хүртэл нэмчихлээ. Тэд бараг юу ч хийж чадсангүй. Аргагүй ээ, одоо удахгүй орон нутгийн сонгууль болох гэж байна. Дөнгөж эрх баригч болчихоод дөрвөн жилийн дараах сонгуульдаа бэлтгэж, ард түмэнд таалагдах гэж явдаг нөхдүүд шүү дээ гэд. Харин одоо орон нутгийн сонгууль хаяанд ирчихсэн байхад таалагдах бүхнээ хийхгүй гээд ч яах юм билээ. Харамсалтай нь зөв хийж чадахгүй байгаад л учир байна. Улс орон хэцүүдсэн, хямарсан, эдийн засаг элгээрээ мөлхөх дөхсөн, гадаад өр төлөх цаг тулчихсан үед “Бид сонгуулиар тэгж амласан. Манай мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй” гэж ажиллах ёстой бил үү. Ёстой л ганган харагдах гэж идэр есийн хүйтэнд шилэн оймс өмсч гүйдэг годогносон хүүхэн шиг л загнаж байна даа. Эцэстээ энэ

бүх шалбаагнаасаа гарах аргаа ердөө л өмнөх эрх баригчдыг муулах гэж муйхарлаад байна. МАН-ын бүлгийн дарга нь өнгөрсөн дөрвөн жилд АН-ын тарьсан балгийг 10 жилийн дараа ч арилгаж, илааршуулж чадахгүй гэх маягийн юм яриад л. Энд нэг л үнэн юм байгаа. Одоогийн нөхцөл байдал хаа байсан 10 гаруй жилийн өмнөөс л ихтэй. Улстөрчид улс орон, эдийн засгаараа байнга тоглож байсны гай одоо тулж ирчихээд байна. Тэд тоглоомоо яаралтай зогсоохгүй бол улс сүйрлээ. Тийм болохоор одоо улс орноо өөд татах ажил хийх ёстой болохоос биш хий боргож, өнгөрснөө мууллаа гээд хэн ч бидний эдийн засгийг өөд нь татаад өгөхгүй. Гадаад өрийг төлөхгүй. Тэртээ тэргүй тэр энэ нам гэлтгүй та нарын өөрсдийн чинь тарьсан гай. Одоо бусдыг муулж, өнгөрснөө үгүйсгэж, “хий боргох”-ын оронд зоригтойхон шийдвэр гаргаад, “хазалт”-аа хазаад л яв.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Нийтлэлч
Б. Баабар:

Ямар ч тэнэг
татвар
төлөгч төрөөс
ухаантай
байдаг

АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА



✓ Зах зээлдээ тэргүүлэгч худалдааны компанид дараах ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж байна.

-МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР

✓ Ажлын байрны зорилго:

Компанийн реклам сурталчилгаа, олон нийтийн харилцааны бодлогын хүрээнд харилцагчид, зах зээл, хэрэглэгчидэд чиглэсэн бүх төрлийн реклам сурталчилгаа, идэвхижүүлэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хянах, үр нөлөөг нь үнэлэх, дүгнэх, борлуулалтыг нэмэгдүүлэх

✓ Тавигдах шаардлага:

- ✓ Маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- ✓ Баримт бичиг боловсруулах, тооцоо судалгаа хийж, дүгнэлт өгөх чадвартай
- ✓ Илтгэх, танилцуулах, олон нийттэй харилцах өндөр үр чадвартай
- ✓ Удирдан зохион байгуулах, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй
- ✓ Хувийн зохион байгуулалт сайтай
- ✓ Багаар ажиллах чадвар сайтай

✓ Бүрдүүлэх материал:

- ✓ CV буюу өөрийн танилцуулга
- ✓ Бакалавр болон магистрын дипломын хуулбар
- ✓ Цахим үнэмлэхгүй хуулбар
- ✓ Сүүлийн 3 сард авахуулсан өнгөт 3x4 цээж зураг 1%

Холбоо барих:

Материал хүлээн авах хаяг:

Материал хүлээн авах эцсийн хугацаа:

9595-0095

Erinbileg1@gmail.com

2016.09.11

ДЭЛХИЙ

Парист дүрвэгсдэд зориулсан кэмп нээлтээ хийнэ

Францын нийслэл Парис хотод иргэний дайн, ядууралд өртсөн орноос тус улсын бараадан ирэх дүрвэгсдэд зориулсан анхны кэмп ашиглалтад ороход бэлэн болжээ. Тус барилгын албан ёсны нээлт ирэх сарын дундуур зохион байгуулагдах юм байна. Гэвч олон нийтийн дунд тус барилгыг ашиглалтад оруулж, шаардагдах тоног төхөөрөмжөөр хангаснаар дүрвэгсдийн их урсгалыг дэмжиж буй хэрэг болно гэсэн болгоомжлол ч гарах болжээ. Гэхдээ тус хотын дарга болон тус улсын Ерөнхийлөгч хүмүүнлэгийн талаар баримтлах бодлоготойгоо уялдуулан тайлбарлахыг хичээж байгаа аж. Кэмп Парисын хойд хэсгийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүсэд байрлах юм байна. Ирэх сард барилга ашиглалтад орсноор энэ оны сүүлч хүртэл нийтдээ 900 орчим хүн хүлээн авах гэнэ. Үүнээс эрчүүд 600, эмэгтэйчүүд 350-ыг хүлээн авахаар төлөвлөжээ. Түүнчлэн, ирсэн зочид амьдрах байраа олох хүртэл чанга харуул хамгаалалтын дор ихдээ 10 хоног байгууламжид амьдрах юм байна.

Хятадын Элчин сайдын яаманд уйгарууд халдлага үйлджээ

Киргизийн нийслэл Бишкек хотод байрлах Хятадын Элчин сайдын яамны гадна хашааны үүдний хэсэгт өнгөрсөн сарын 30-нд амиа золиослох террорист халдлага болсон. Тухайн үед Миңдүбиши моторс компанийн Делика маркийн машин Элчин сайдын яамны хашааг мөргөж, удалгүй дэлбэрсний улмаас гурван алба хаагч гэмтэж бэртсэн байдаг. Тэгвэл уг халдлагыг уйгарууд үйлдсэн гэдгийг Киргизийн аюулгүйн албанаас мэдээллээ. Тэд Хятадаас тусгаар тогтнох хүсэлтэй Шинжаан Уйгарын босогчдын нэг уг халдлагыг үйлдсэн болохыг тогтоосон байна. Хэргийг эргэн сануулбал, Бишкек хотын Хятадын Элчин сайдын яаманд өнгөрсөн сарын 30-нд делика маркийн машин хаалга мөргөн зогсч, удалгүй дэлбэрсэн юм. Машиньг жолоодож явсан эрэгтэй хэргийн газарт амиа алдаж, гурван алба хаагч гэмтсэн. Хэргийг аюулгүйн албаныхан террорист халдлага хэмээн үзэж мөрдөн байцаалтын ажлыг эхлүүлсэн байна. Улмаар Шинжаан уйгарын босогчдын бүлэглэлд харьяалагдах 33 настай уйгар эр үйлдсэн болохыг тогтоожээ. Одоогоор энэ хэрэгт холбогдуулан таван хүнийг баривчилснаас гадна террорист халдлага үйлдэхийг даалгасан хэргээр дөрвөн хүнийг интерполоор эрэн сурвалжилж эхэлсэн байна.



СИРИЙН

ЭРХ БАРИГЧИД ХИМИЙН ХАЛДЛАГА ҮЙЛДЭВ

Б.ДАВААХҮҮ

Иргэний дайны хөлд таван жилийн турш нухлагдаж буй Сирийн Алеппо хотын энгийн иргэд сүүлийн үед амьсгалын замын өвчнөөр өвчлөх нь ихэсчээ. Сирийн Алеппо хотод эдүгээ ширүүн дайн өрнөсөн хэвээр байгаа төдийгүй Засгийн газрын арми болон босогчид хоорондоо тэмцэлдэж байгаа юм. Харин тэрхүү дайны хохирогч нь энгийн иргэд болж байна. Одоогийн байдлаар мужийн зүүн хэсэгт босогчид хяналтаа тогтоосон бол баруун этгээдийг Сирийн Засгийн газрын арми хянаж байгаа юм. Тэгвэл Засгийн газрын тал нисдэг тэргээр Алеппо хотын зүүн хэсэгт химийн халдлага үйлдсэний улмаас энгийн иргэд үй олноороо

амьсгалын замын өвчин тусч, эмчилгээ хийлгэх болжээ. Их Британид байрлан үйл ажиллагаагаа явуулах Сирийн хүний эрхийн байгуулагаас мэдээлснээр цэргийнхэн торхтой тэсрэх бодис хаясны дараа 70 гаруй хүн ийм төрлийн өвчнөөр өвчлж, эмчилгээ хийлгэх болсон байна. Зарим албаны эх сурвалжийн мэдээлснээр Башар ал Ассадын армийнхан хотын зүүн хэсэгт хлорын хий ашиглажээ. Тэд нисдэг тэргээр хэд хэдэн торхтой хлорын хийг авчирч, Алеппо хотын зүүн хэсгийн Суккари гэх дүүргийн нутаг дэвсгэрт хаяжээ. Үүний улмаас энгийн иргэд амьсгалын замын өвчин тусч эхэлсэн бөгөөд одоогоор хүн нас барсан гэсэн мэдээлэл байхгүй байгаа юм. Суккари дүүргийн нэг иргэн Франц пресс агентлагт өгсөн

ярилцлагадаа “Агаараас цохилт өгсний дараа манай дүүрэгт сонин эхүүн үнэр үнэртэж эхэлсэн. Надаас гадна маш олон хүн үүний дараа амьсгалын замын өвчнөөр өвдсөн” гэжээ. Засгийн газрын арми болон хэт даврагч бүлэглэлийн аль аль нь энгийн иргэд рүү химийн бодис ашиглан халдлага үйлдэж байв. Гэхдээ өнгөрсөн таван жилийн турш нэг нэг рүүгээ бурууг тохсоор ирсэн билээ. НҮБ-ын шинжээчид өнгөрсөн сард гаргасан тайландаа Башар ал Ассадын хүчнийхэн эдүгээг хүртэл багадаа хоёр удаа химийн халдлага үйлдсэн хэмээн дурьдсан байв. Тодруулбал, 2014 болон 2015 онд нэг нэг удаа халдлага үйлдэж байжээ. Гэвч ОХУ тус дүнг эргэлзээтэй гэж дүгнэсэн бол НҮБ дахь Сирийн төлөөлөгч мөн үгүйсгэсэн юм. Турктай

хиллэх Сирийн хойд этгээдийн Алеппо хот 2007 оны байдлаар 4.393 сая хүн амтай тус улсын томоохон хотуудын нэг байлаа. Харин эдүгээ дайны утаа суунаглаж, гэм зэмгүй энгийн иргэд амиа алдсан “цусан хот” болж хувирчээ. Цагтаа 4.3 сая хүн амтай байсан эл хотод хамгийн сүүлд авсан мэдээгээр 700 мянга хүрэхтэй үгүйтэй хүн амьд үлдэхийн төлөө тэмцэж байна. Таван жилийн өмнө 2011 оны гуравдугаар сард “Арабын хавар” нэртэй Хойд Африк, Ойрхи Дорнодыг орнуудыг эмх замбараагүй, үймээн самуунд дуудсан давалгаа Сири улсыг ч тойроогүй. Үүнд Алеппо хот хамгийн ихээр өртөж, хүн төрөлхтний түүхэн дурсгалт барилга байгууламж хүн зоноо алдаад дуусч буй нь энэ.

БНАСАУ-ын пуужингийн технологи улам сайжирч байна

АНУ-ын Батлан хамгаалах яамны хэвлэлийн албаны төлөөлөгчид БНАСАУ-ын харвасан дунд зайн тусгалтай Родонг загварын пуужингуудын нислэгийн чадвар, байр онох чадварыг шинжлэн үзсэний эцэст Пхеньяны пуужингууд улам сайжирч байгааг дэлхий дахинд сануулсан байна. Пентагоны үзэж байгаагаар даваа гарагт болсон пуужингийн туршилтуудыг хөдөлгөөнт суурин дээрээс харвасан байх өндөр магадлалтай байгаа аж. Түүнээс гадна шинээр харвасан пуужингууд нь өмнө нь туршиж байсан ийм төрлийн зэвсгээс

хамаагүй илүү нарийн цэцтэй болсон байна гэдгийг цохон тэмдэглэв. Одоо НҮБ-ын Аюулгүйн зөвлөл тэдний гаргасан тогтоолуудыг үл тоон байнга пуужингийн туршилт хийж байгаа БНАСАУ-ын эсрэг ямар арга хэмжээ авах талаар хэлэлцэхээр хуралдах гэж байна. Гэвч энэхүү хурлаас гаргасан аливаа шийдвэр БНАСАУ-ын талд нөлөөлнө гэж үзэх шинжээчид цөөхөн байгаа юм. Учир нь энэ оны эхний хагаст БНАСАУ-ын хийсэн пуужингийн туршилтуудын эсрэг НҮБ-ын Аюулгүйн зөвлөл удаа дараа хориг арга хэмжээ авсан ч тодорхой үр дүнд

хүрээгүй. Олон улсын шинжээчид Пхеньянтай хүч хэрэглэх замаар бус, уян зөөлөн бодлого явуулж харьцаж чадвал илүү үр дүнд хүрэх боломжтойг сануулж байгаа. Харин БНАСАУ ямар санаа зорилготойгоор пуужингийн туршилт хийсэн талаараа ямар нэгэн мэдээлэл хийгээгүй байна. Гэхдээ Пхеньян хөдөлгөөнт суурин дээрээс буюу шумбагч завинаас пуужинг харвах чадалтай болохоо дэлхий дахинд харуулснаар барууны орнуудад өөрийн болзлоо тулгах боломжийг нэмэгдүүлж байна гэж таамаглах цэргийн шинжээч цөөнгүй байгаа юм.



ОНЦЛОХ МЭДЭЭ

В.ПУТИНЫ МАШИН ОСОЛДОВ

Дэлхийн хүчирхэг удирдагчдын нэг ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины албан хэрэгцээндээ хөлөглөдөг тас хар өнгийн BMW маркийн машин Москвагийн төв хэсэгт осолдоо. Осол болох үед В.Путин машинд байгаагүй аж. Харин жолооч нь газар дээрээ амьсгал хураасан байна. Машин Москва хотын Кутузовскийн өргөн чөлөөний замын хоёр урсгалыг заагласан тусгай зориулалтын замаар хурдалж явахдаа жолоодлогоо алдаж, сөрөг урсгалаар явж байсан Мерседес маркийн машинтай мөргөлдөн, онхолджээ. Одоогоор жолоочийн нэр тодорхойгүй байгаа. Гэхдээ 40 гаруй жил машин жолоодсон

туршлагатай, В.Путины итгэлийг олсон эрхэм байжээ. Харин Мерседес маркийн машины жолооч хүнд гэмтэн эмнэлэгт эмчлүүлж байгаа юм байна. В.Путины албаны ажилдаа унадаг тус машин ОХУ-ын Лордын танхимд бүртгэлтэй аж. Одоогоор цагдаагийн байгууллагуудын машинд ямар нэг асуудал байсан эсхийг шалгаж байгаа юм байна. Ослын дараа Кутузовскийн өргөн чөлөөний замыг хэдэн цагийн турш хаасны эцэст, хэвийн үйл ажиллагаанд шилжсэн байна. Дашрамд дурьдахад, ирэх жилээс ОХУ-ын төрийн тэргүүн хамгийн сүүлийн үеийн тансаг тодорхойгүй байгаа. Гэхдээ 40 гаруй жил машин жолоодсон

MMINFO

ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ



MMINFO АПП

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...



TATAX PLAY STORE



TATAX APP STORE

ОНЦЛОХ ХУУДАС

ӨҮЙ ГҮ ӨҮЙ АҮ?

ӨӨРИЙН ГЭСЭН КАПИТАЛТАЙ Ц.МӨНХ-ОРГИЛ

Ч.ЧУЛУУН

“Хэн нь хэн бэ” булан энэ удаад Гадаад харилцааны сайд Ц. Мөнх-Оргилыг онцолж байна.



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

...2008 онд намын дарга С.Баяр нь түрийний бөөсийг толгойд гаргаж болохгүй гэж үзсэн үү, яасан эсвэл чадна гэж бодсон уу огт “танихгүй” Баянгол дүүрэгт нэр дэвшүүлж шандсыг нь шалгахад Ц.Мөнх-Оргил хэн болохоо дахин харуулж намдаа суудал авчирсан. Үнэндээ тэр нэг зэрвэсхэн үе түүнийг улс төрд од адил гялалзуулсан юм,” хар өдөр” тохиох хүртэл...

Энэ эрхмийн нэр хүнд эгэл ардуудын дунд тийм ч сайн биш. Ялангуяа, 2008 оны долдугаар сарын 1-ний өдрийн хар үйл явдлын улмаас амь үрэгдсэн таван хүн болоод эдүгээ шоронд улс төрийн хэргээр ял эдэлж байгаа 300 гаруй иргэний ар гэр, ах дүү төрөл садныхны хувьд цэнхэр дэлгэцээр Ц. Мөнх-Оргил гарах бүрийд зүрх нь дэлсч сүйд болцгоодог байх. Үнэндээ түүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан тэр жил Монголын төр эгэл түмэн рүүгээ буу шагайж, тавын таван хүний амь үрэгдсэн юм. Хүүгээ алдсан эцэг эх, ханна алдсан бүсгүй, эцгээ шоронд явуулсан үрс яаж түүнд сайн байх билээ дээ. Тухайн үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хар дарсан өдөр хийгээд ХЗДХ-ийн сайд асан Ц. Мөнх-Оргилын талаар “Ерөнхийлөгчийн зарлигаар “Онц байдал” тогтоож, ХЗДХ-ийн сайд Ц.Мөнх-Оргилоор ахлуулсан шуурхай штабыг байгуулж, түүний удирдлага дор цагдаагийн байгууллага бүхэлдээ үүрэг гүйцэтгэхдээ “Тусгай төхөөрөмжлөгдсөн техникээр гудамжинд явсан хүмүүсийг элдэж, байлдааны гэрэлт сумаар буудаж заримынх нь амь насыг хөнөөж, цөөнгүй тооны иргэдийг шархдуулсан нь тодорхой боллоо. Бууны суманд өртөж шархадсан залуучууд Улсын клиникийн нэгдүгээр эмнэлэгт ухаангүй хүргэгдэж очоод нас барсан тухай эмч сувилагч нар нь ярьж байна. ийм дүрс бичлэгийг цэнхэр дэлгэцээр харсан хэн бүхний зэвүүцэл хорслыг хүргэлгүй яахав дээ. Сэтгүүлчид Онц байдлын бүс рүү оролгүй гудамжнаас АКА бууны сумны шинэхэн хонгнуудыг түүж зургийг нь авч хэдэн оны сум болохыг цэргийнхнээс тодруулцааж байна. Сумны хонгио хаяагүй тааралдаж байгааг бодоход жагсагчдын өөдөөс галт зэвсэг хэрэглээгүй гэх ХЗДХ-ийн сайд Ц.Мөнх-Оргилын мэдээлэл ор тас үндэслэлгүй болох нь хоёрхон өдрийн дотор батлагдав” хэмээн бичиж байсан нь эдүгээ сонины хуудаснаа шарлан

үлджээ. Мөн бас нэг сонинд нийтлэгдсэн “Сайд Ц.Мөнх-Оргил хуулийн бодлогыг хэрхэн завхруулсан бэ” гарчиг дор “Их эвслийн Засгийн газар”-ыг “Эрэл”-ийн Б.Эрдэнэбат, М.Энхсайхан нар самарч тараахад гишүүн Ц.Мөнх-Оргил ХЗДХ-ийн сайдын албанд очсон нь жирийн хэрэг биш бололтой. Энэхүү томилгооны дараа казиногийн хэрэгт холбогдож хэзээ мөдгүй шоронд дуудагдах дээрээ тулаад байсан УИХ-ын гурвын гурван гишүүнд холбогдох хэрэг цайрлаа. Тэдний бүрэн эрхийг түдгэлзүүлж мөрдөхөөр Монгол Улсын хууль цаазын Ерөнхий зөвлөх, Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг хоёр ч удаа УИХ-д албан тоот хүргүүлээд барсангүй. Онц хүнд гэмт хэрэг үйлдэгсэд Ц.Мөнх-Оргил сайдын үед ингэж дархлаажлаа гэж үү. Түүнчлэн Хадгаламж зээлийн хоршоодын 64 тэрбум төгрөгийн луйвар, Хадгаламж банкнаас алдагдсан 14.3 тэрбум төгрөгөөр нэр бүхий УИХ-ын гишүүд Сөүл хотноо казино тоглож үрэн таран хийсэн хэрэг, УИХ-ын гишүүн Ц.Батаа нисдэг тэргээр ан хийж яваад осолд орж улсад үлэмж хэмжээний хохирол учруулсан хэрэг, галт тэрэг мөргөлдөж эрдэнэт хүний амь нас үрэгдсэн гэмт үйлдэл, Ми-8 нисдэг тэрэгний сүйрлээр олон арван аврагчдын амь насыг хөнөөсөн хариуцлагагүй явдалд нэр бүхий албан тушаалтнуудад хуулийн хариуцлага хүлээлгэх ёстой ч ХЗДХ-ийн сайд Ц.Мөнх-Оргил хуулийг завхруулснаар хавтаст хэргүүд хаагдсан гэж бичиж байсан нь мөн л цахим ертөнцийн архивт өчигдрийн мэдээлэл аятай тодоос тод дурайж үлдсэн байх жишээтэй.

Харин МАН-ын гишүүний тухайд Гадаад харилцааны сайд Ц. Мөнх-Оргил өөгүй өндөг шиг цэвэрхэн улстөрч. Мэдлэг боловсрол, улс төрд хуримтлуулсан туршлага, хашиж байсан албан тушаал зэргээрээ намынхаа нөхөд цаашлаад энэ цагийн улстөрчдийг ардаа орхино уу гэхээс ард

нь бичигдэх хүн биш. Боловсрол гэхэд л Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийг Олон улсын эрх зүйч мэргэжлээр 1988 онд, АНУ-ын Харвардын их сургуулийн Хуулийн сургуулийг 1996 онд тус тус төгссөн, орос, англи, франц хэлтэй гээд л явж өгнө. Монголын улстөрчид эхлээд УИХ гэсэн дамжаанд дөрвөн жил суралцсаны эцэст Харвардын их сургуульд суралцах мөнгөтэй болж авдаг бол мань эр улс төрд хөл тавихаасаа өмнө төгссөн гэдгээрээ анхдагч нь ч байж мэднэ. Тэрбээр С.Батболдын хүн. Үүнийг нь улс төрийн хүрээнийхэн хийгээд энэ сэдвийг сонирхдог бүх хүн мэддэг. Түүний улс төрд хөл тавьсан түүхийг эргэн санахад, Харвардын их сургуулийг төгссөн залуухан эрхзүйчийг 2000 онд эх орондоо хөл тавихад тухайн үед нэр нөлөө нь тэнгэрт хөвж явсан Н.Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар томилж байв. Яг энэ үед Японы “Марубени” корпораци Монголын Засгийн газраас 18 сая ам.доллар нэхэмжилж, Лондонгийн шүүхэд өгсөн тухай дуулиан дэгдчихсэн үе таарсан нь чухамдаа Ц.Мөнх-Оргилд олз болж, ямархан залууг дэд сайдаар томилсныг, улс төрд ямар шинэ хүн орж ирснийг харуулж чадсан үйл явдал болсон гэдэг. Мань эр анх УИХ-ын 2004 оны сонгуулиар МАХН-аас Сүхбаатар дүүрэгт нэр дэвшин ялалт байгуулсан нь нэр хүндийг улам өсгөж орхисон. Харин 2008 онд намын дарга С.Баяр нь түрийний бөөсийг толгойд гаргаж болохгүй гэж үзсэн үү, яасан эсвэл чадна гэж бодсон уу огт “танихгүй” Баянгол дүүрэгт нэр дэвшүүлж шандсыг нь шалгахад Ц.Мөнх-Оргил хэн болохоо дахин харуулж намдаа суудал авчирсан. Үнэндээ тэр нэг зэрвэсхэн үе түүнийг улс төрд од адил гялалзуулсан юм,” хар өдөр” тохиох хүртэл.

МАХН-аас туурга тусгаарласан тэр жил С.Батболд намын даргаар сонгогдсон даруйд Ц.Мөнх-Оргилын нэр шинэ намын шинэ ерөнхий нарийн

бичгийн даргад яригдаж байсан юм. Тэргүүн шадар сайд У.Хүрэлсүх намынхаа УЗХ-д санал болгосон юм гэнэ лээ. Гэвч намын удирдах зөвлөлийнхөн өнөө гайт долдугаар сарын 1-ний хэрэг дахин сөхөгдөж мэдэх аюултай гэж үзээд дэвшүүлэхээс татгалзсан аж. Тэр цагаас хойш 2016 он хүртэл мань эрийн нэр улс төрийн ямар ч томилгоонд дурьдагдахаа больсон. Мэдээж, С.Батболд нь жийж орхисон хэрэг. Гэхдээ Ц.Мөнх-Оргил өөрийн гэсэн капиталтай улстөрч гэдгийг энд онцлох ёстой. Ц.Элбэгдоржийн тэргүүлж байсан Засгийн газарт Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан гэдгийг нь хүмүүс мэддэггүй, санадаггүй юм билээ. МАН-ын шинэ сайд нарыг зүй ёсоор өнгөлж байгаа хүн бол яах аргагүй Ц.Мөнх-Оргил. Сайд нарыг томилох тухай асуудал яригдахад Хууль зүйн яамыг толгойлох болов уу гэсэн таамгийн хэвлэлүүд бичиж байв. Харин тэрбээр Гадаад харилцааны сайдаар томилогдсон. Түүнд энэ салбарыг аваад явах туршлага уг нь бий. Ажил амьдралынхаа гараа Гадаад харилцааны яамнаас эхэлж, АНУ дахь Монголын ЭСЯ-д атташегээр гурван жил, Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суух байнгын төлөөлөгчийн газарт хоёрдугаар нарийн бичгийн даргаар дөрвөн жил томилогдон ажилласан туршлагатай. Ийнхүү тэрбээр 12 жилийн дараа дахин Гадаад харилцааны яамны сайдын суудалд сууж байгаа нь энэ. Хувь хүнийхээ тухайд хэнтэй ч ойлгоцож чадах авьяастай нэгэн. Эмч ээж, аавын гэрт хүмүүжсэн Ц.Мөнх-Оргил эцэг, эхийнхээ мэргэжлийг өвлөж эмч болбол болох л байсан гэдэг. Гэхдээ тэр хуульч, олон улсын харилцааны мэргэжлийг сонгосон нь буруу болоогүй. Одоо түүнд эмээх зүйл үгүй. Сэтгүүлчид ч нэг их нүд үзүүлэхээ больсон байна лээ. Яамныхаа дэргэд цэцэрлэг байгуулах гээд өөрөө шаврыг нь зуураад зогсч байсан түүнийг цаг үе өршөөсөн биз ээ.

ЧУХАЛ СЭД

ХУВИЙН ХЭВШИЛ, БОЛОХГҮЙ

гэж байдаг. Энэ дотор миний ярьсан 50 маштабын зураг 1:200 маштабын геологийн зураг бусад геофизик, геохимийн, нэгэнт улсаас мөнгө зараад гүйцэтгэгчид ажлын мэдээллүүд нийтэд нээлттэй хэвээр байгаа. Нийтэд нээлттэй байгаа мэдээлэл рүү орж сонирхохыг хүссэн хэн бүхэнд Ашигт малтмал, газрын тосны газрын харьяанд байгаа геологийн фонд буюу мэдээллийн сан нээлттэй. Сонирхсон иргэд анхдагч тайланг авч үзэх эрхтэй. Ийм байдлаар үйлчилжирсэн. Үүнийг өөрчлөх шаардлага тулгарсан. Өөрөөр хэлбэл, нэгэнт хуулиар зөвшөөрсөн нээлттэй мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, шаардлагатай бол олон улсад нээлттэйгээр англи болон бусад хэл дээр орчуулах, хэвлүүлэх зайлшгүй шаардлагатай болсон. Гэхдээ энэ ажил хоёр талтай. Эхнийх нь, Монголын геологийн салбарын хөгжлийн түвшинг олон улсад гаргаж тавих давуу талтайгаас гадна гадаадын том хөрөнгө оруулагчдад энэ улс геологийн нөөцийн хувьд сонирхол татахуйц орон мөн үү, биш үү гэдэгт хариулт болохуйц мэдээлэл хангах нөхцлийг бүрдүүлнэ. Хөрөнгө оруулагчдын хувьд геологийн мэдээлэл нь хэр үнэмшилтэй юм, ил тод байж чадаж байна уу, хэтийн төлөв нь ямар юм гэдгийг нь харж, судалж байж гэмээнэ Монголд орж ирэх эсэхээ шийддэг. Энэ бүх зарчимд нийцүүлэн зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Ашигт малтмал, газрын тосны газрын харьяанд эрдэс, баялгийн мэдээлэл технологийн төв байгуулагдаж байгаа. Төвийн үйл ажиллагаа цаашид улам бэхжиж, орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлсэн нийтэд нээлттэй мэдээллийг түргэн шуурхай хүртээмжтэйгээр боловсруулдаг ийм нэгж байх ёстой гэж үзэж байгаа.

Эрдэс, баялгийн мэдээллийн сангийн үндсэн мэдээлэл нь өнгөрсөн XX зууны дундуур, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын үр дүн байдаг. Сүүлийн жилүүдэд нөөцийг шинэчлэн тогтоох асуудалд улс бус аж ахуйн нэгжүүд өөрсдөө хөрөнгө гаргаж байх шиг байна. Ийм тохиолдолд тухайд аж ахуйн нэгжийн тогтоосон нөөцийг ил тодоор

зарлах, мэдээллийн санд байршуулах нь байгууллага, хувь хүний нууцад, өмчид халдсан үйлдэл биш үү?

Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийнхөө лиценз бүхий талбайд хайгуул хийх, нөөцөө тогтоох нь нэгэнт хуулиар хамгаалагдсан байдаг. Тэр утгаараа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр мэдээллийг нийтэд нээлттэйгээр цацах эрх зүйн хувьд байж боломгүй зүйл. Харин манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа, дотоодын болоод олон улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниуд хөрөнгийн биржийн журмын дагуу хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгө, тогтоосон нөөцөө нийтэд ил тодоор мэдээлэх ёстой. Хувийн компаниуд мэдээллээ ил тод байлгах эсэх нь тэдний асуудал. Хууль, эрх зүй орчны хувьд ч мэдээллийг ил тод байлгах, төрөөс энэ талаар зарлах ёсгүй.

-Стратегийн орж газрыг тогтоох тухай асуудал хэсэг бужигнаснаа таг чиг болсон. Энэ ажил ямар төвшинд яваа вэ?

-Стратегийн ордуудын хил хязгаарыг нарийвчлан тогтоох ажлыг эцэслэж чадаагүй байна. Оюутолгой, тавантолгой ордуудын нөөц тодорхой хэмжээгээр лицензтэй талбай дотроо бүртгэгдсэн байгаа. Яг энэ хэсэг нь стратегийн орд, үүнээс гаднах нь стратегид хамаарагдахгүй шүү гэж эцэслэн тогтоож чадаагүй. Нэг талаас техникийн хувьд асуудалтайн дээр хууль, эрх зүйн орчныг нь тодруулах шаардлага гарсан. Өнөөдрийн байдлаар, стратегид хамааруулсан ордуудын нөөц баялгийг тухайн лицензтэй талбай дээр тогтоогоод цэвэр стратегийн ордод хамааруулчихсан явж байх жишээний.

-Бодит амьдралаас харахад Азиболоод Европийн хөрөнгө оруулагчдын баримталж буй зарчмын нь өөр өөр байдаг. Гадны хөрөнгө оруулагчдад өнөөдрийн нөхцөл байдалд ямар зөвлөгөөг өгөх нь хамгийн том тус вэ?

-Монгол Улсын эрдэс баялгийн салбар бол тэргүүлэх ач холбогдолтой. Тийм учраас УИХ, Засгийн газраас энэ салбарын эрх зүйн орчныг тогтвортой байлгаж, ойлгомжтой ил тод байлгах тухайд ажилласаар ирсэн. Эрдэс, баялгийн салбарыг

томоор нь авч үзэх юм бол газрын тос, уул уурхай, геологийн хувьд хууль, эрх зүйн орчин нь харьцангуй ил тод нээлттэй, ойлгомжтой болсон. Дээр нь эрх зүйн орчин нь харьцангуй тогтвортой гэж ойлгож болно. Ашигт малтмалын тухай, Газрын тосны хууль болон бусад хуулиудаа бид өөрсдөө савлуулаад байх аваас нэг талаасаа хөрөнгө оруулагчид, нөгөө талаас Монгол Улсын дэлхийд өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлнө. Энэ бүхнийг ойлгосон учраас яам болон харьяа агентлагын зүгээс зарчмын өөрчлөлтийг аль болох хийхээс татгалздаг болсон. Өрсөлдөх чадвараар Ази, Африк, Өмнөд Америкийн улсуудтай харьцуулахад хөрөнгө оруулагчид Монгол Улсыг нэлээд сайн хуультай оронд тооцдог. Тэр хэрээр өрсөлдөх чадвартай хэмээн үнэлэгдэх болсон. Ялангуяа, манай улсын татварын орчин гадныханд маш тааламжтай. Сүүлийн хэдэн жил алтны салбарт Монгол Улс маш тааламжтай, өрсөлдөх чадвартайг тооцогдож буй.

-Ашигт малтмал, Газрын тос хоёр нэг бодлогод зангидах боллоо. Үр дүн нь ямар байх бол?

-Өмнө нь тус тусдаа агентлаг байсан. Засгийн газрын бүтцэд нэгдсэн нэг агентлагт багтсан. Хоёулаа улсын эдийн засгийн өсөлтөд жинтэй хувь нэмэр оруулсаар ирсэн салбар. Энэ хоёрт ижил төстэй, бие биетэйгээ гарцаа байхгүй уялдах шижмүүд бий. Орон нутгийг дэмжих, байгаль экологи, нөхөн сэргээлт, дээрээс нь хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй байдал гээд олон асуудалд нэгдсэн нэг бодлогоор хандах боломж байдаг. Нөгөө талаас геологич гэдэг талаас нь харж үзэх юм бол газрын тос болоод бусад ашигт малтмалын тухайд геологийн нэгдсэн сан гэдгээрээ нэгдэх зайлшгүй шаардлага тулгарсан. Эцэст нь хэлэх юм бол Монгол Улсад эрдэс, баялгийн салбар нэг бодлогоор, өөр хоорондоо уялдаа холбоотой явах ёстой. Үр дүн нь эрдэс, баялгийн салбарын мэдээллийн сан нэгдсэн болох гэдгээрээ илүү



Гэрэл зургийг Г. АРГУУЖИН

ач холбогдолтой юм. Газрын тосны олборлолт явуулж байгаа талбайтай уялдуулан дэд бүтэц болон уул уурхайн асуудлыг бодлогоор нэгдсэн нэг төлөвлөлтөд нийцүүлэх боломж бүрдэнэ.

-Бороогийн алтны ордны эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал ойрын үед шийдэгдэх болов уу. Засгийн газрын байр суурь ямар байгаа бол?

-Доогуур тодорхой хэлэх зүйл алга. Стратегийн ордод хамааралтай учраас төрийн захиргааны төв байгууллагын эрхийн асуудал.

-Та геологич уу эсвэл эрхзүйч байгаад уул уурхайн салбарт мэргэшил үү?

-Би бол геологич. Ашигт малтмалын хайгуулаар мэргэшсэн геологич. Төрд алба хашихаас өмнө Монголд үйл ажиллагаа явуулдаг гадны компанид ажиллаж байгаад Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт мэргэжлээрээ ажиллах болсон. Ажил үүргийн дагуу уул уурхайн салбарын хууль, эрх зүйн чиглэлд илүү их дадлага туршлагыг хуримтлуулсан гэж хэлж болно. Үйлдвэрлэл дээр ажиллаж байсны хувьд алдаа дутагдал, хүндрэл бэрхшээл хаана байдгийг нь би мэднэ. Сүүлийн дөрвөн жил бодлогын яаманд ажиллахдаа өөрт учирч байсан хүндрэл бэрхшээлтэй асуудлуудыг бодлогын хүрээнд хэрхэн яаж шийдвэрлэх ёстой юм бэ гэдэг дээр нэлээд анхаарч ажилласан. Энэ хүрээнд мэргэшсэн гэхгүй ч тодорхой хэмжээний мэдлэг, туршлага хуримтлуулжээ.

-БНМАУ геологичдоо голдуу ЗХУ-д бэлтгэсэн байдаг. Таны тухайд?

-Би 1997 онд МУИС-ийг төгсч улмаар 2000-2006 онд ХБНГУ-д байгаль орчин геологийн чиглэлээр магистр, Ашигт малтмалын хайгуулын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан. Миний эцэг Х.Балдорж нь нэр хүндтэй геологич байлаа. Салбарын хөгшчүүд бол аавыг минь андахгүй. Тэгэхээр би удам дагасан геологич. Аавыгаа дагаж явсаар энэ мэргэжилд дурлах болсон. Их сайхан мэргэжил.

ЗАСГИЙН ГАЗАР

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ХУУЛИЙГ УИХ-Д ӨРГӨН БАРИХААР БОЛЛОО

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд УИХ-д өргөн барихаар боллоо. Гэр бүлийн хүчирхийллийг зөвхөн зөрчлийн хэмжээнд авч үзэж байсныг өөрчилж, гэмт хэрэгт тооцон, зохих ял шийтгэх талаар Эрүүгийн хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулсан байна. Хуулийн төсөл батлагдсанаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэл үйлдэгчид зохих шийтгэл хүлээлгэх эрх зүйн орчин бүрдэх юм.



Гэрэл зургийг Г. АРГУУЖИН

УБТЗ-ын ерөнхий хувь нийлүүлэгчийг томиллоо

Монгол-Оросын хувь нийлүүлсэн "УБТЗ" нийгэмлэгийн Монголын талын Ерөнхий хувь нийлүүлэгчээр

Зам, тээврийн хөгжлийн сайдыг томилсон тогтоол баталлаа. Тус нийгэмлэгийн хувьцааны 50 хувийг Монгол Улс эзэмшдэг бөгөөд Монголын талын ерөнхий хувь нийлүүлэгчээр өмнө нь Засгийн газрын Хэрэг

эрхлэх газар, Сангийн яам ажиллаж байсан юм. Монголын талын 50 хувийн хувьцаа бүхлээрээ нэгдмэл, салбарын яамандаа байх нь зөв гэж Засгийн газар үзлээ.

Ю.Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэх зардлыг шийджээ

Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар боллоо.

Буцалтгүй тусламжийг гэр хорооллын дахин төлөвлөлтөд зарцуулна

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар албан ёсны айлчлал хийсэн БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ, Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абе, Монгол Улсын

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын урилгаар албан ёсны айлчлал хийсэн БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Коцянь, БНСВУ-ын Ерөнхий сайд Нгуэн Суан Фук, Бүгд Найрамдах Сингапур Улсын Ерөнхий сайд Ли Хсиен Лүүн нарын айлчлалын дүнг хэлэлцлээ. Эдгээр айлчлалын хүрээнд тохирсон асуудлуудыг шийдэх чиглэлээр шуурхай ажиллахыг холбогдох сайд нарт үүрэг болголоо. Тухайлбал, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Коцянь айлчлалаар олгох болсон 350 сая юанийн буцалтгүй тусламжийн зарим хэсгийг гэр хорооллын дахин төлөвлөлтөд зарцуулах чиглэлээр шуурхай ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайдад үүрэг болголоо.

Тал нутгийн цахим мэдээлэл

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

Усан дороос



Б.ДАВАА

Бразилын Рио Де Жанейро хотноо зохион байгуулагдсан хүн төрөлхтний эв нэгдлийн бэлгэдэл зуны 31 дэх удаагийн олимпын наадмын нэгэн торгон агшныг уншигчиддаа сонирхуулж байна. Спортын ертөнц дэх онцгой агшныг алдалгүй өөрийн дурандаа буулгагдаараа алдартай АНУ-ын

гэрэл зурагчин Доналд Миралле энэ зургийг авчээ. Тэрбээр олон улсын 30 гаруй тэмцээн уралдаанд түрүүлж байсан юм. 10 метрийн өндөр тавцангаас ус руу шумбан орж буй тамирчны зургийг усан дороос ийнхүү гэрэл зургийн хальснаа буулгасан байна. Түүний энэхүү зураг Риогийн олимпын шилдэг 20 зургийн жагсаалтад багтсан юм.

Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭИ
ЯВДЛУУД

Болор Хуяг

Амнаасаа болж ажлаасаа халагдсаныг уншаад санаанд орчихлоо. Хэдэн жилийн өмнө төгсчихөөд нэг хэвлэлийн компанид ажилд оров оо. Захирал нь өөрөө ярилцагаа аваад л манайх ингэдэг тэгдэг гээд компаниа магтаад сүрхий сүрхий. Цайны цагаараа би ажилчидтайгаа хамт цайнд ордог юм гээд нэг гуанзанд орлоо. Захирал миний хажууд суучихсан би хоолоо идээд хэсэг будаа үлдээчихэв. Тэгсэн захирал "Будаа үлдээдэггүй юм. Наадхаа идчих" л гэж байна шүү. Харин би юу ч саналгүй "Хятад хүн будаа үлдээдэггүй гэнэ лээ" гээд хэлчихсэн юм. Захирал нэг их сонин царайснаа тэндээс гараад "За миний дүү харьж бай. Залгая" гэж байна. Тэгсэнээ орой залгаснаа "Чамайг авахаа болилоо" гэсэн юм даа. Дааганаасаа биш дарвагараасаа болж хагас өдөр ажиллаад халагдаж билээ. Хэхэ.

ОДДЫН АМЬДРАЛ



Ким
Кардашьяны
ҮРГЭЛЖЛЭЛ

Америкийн телевизийн реалити шоуугаар олонд танигдсан цутгай гэр бүлийн отгон охин 19 настай Кайли Женнер үснийхээ хэв маягийг өөрчилжээ. Гадаад төрх, галбираараа эх нэгтэй эцэг өөр эгч Ким Кардашьянтай тун төстэй бүсгүй үснийхээ хэв маягийг яг л Ким Кардашьянтай адилхан янзалсан нь шар сайтуудын анхаарлыг татаад амжив. Төрөлхийн хар үстэй Кайли эдүгээг хүртэл хүрэн, ногоон гэх мэтээр янз бүрийн өнгөөр үсээ өөрчилж байсан юм. Гэхдээ энэ сарын 4-ний өдрөөс хойш ийм

имижийг бүрдүүлэх болжээ. Тэрбээр шинэ үснийхээ зургийг очигдөр инстаграмм хуудастаа оруулсан байх бөгөөд дагагчид нь "Яг адилхан болсон байна", "Хар үс чинь илүү зохицдог", "Үсээ ийм болгочихсон чинь яг л Ким Кардашьян шиг харагдаж байна" гэх зэргээр сэтгэгдэл үлдээсээр байна. Түүний эгч Ким ч үе үе үсээ ийм болгох нь бий. Ямартай ч, өсвөр насны модель бүсгүйн гэнэтийн өөрчлөлт шүтэн бишрэгчдэд нь төдийлөн таалагдахгүй байгаа гэнэ шүү.

Тайлор Свифт **ДАХИАД Л ГАНЦ**
БИЕ БОЛЖЭЭ

Хөрөнгөлөг, мөнгөлөг, сайхан залуусыг бээлий шигээ сольдгоороо алдартай дуучин Тайлор Свифт дахиад л ганц бие болжээ. Эрчүүдтэй гурван сараас дээш хугацаагаар дотно харилцаа үүсгэж үзээгүй дуучин бүсгүйн хувьд ээлжит найз залуугаараа жүжигчин Том Хидлстоныг сонгоод байсан юм. Хөгжмийн ертөнцдөө хэдийнэ танигдсан Калвин Харрисаас салаад ердөө хэдхэн хоносныхоо дараа үеийн залуус дундаас эзэмшсэн боловсролоороо ялгарах жүжигчин залууг уургалж чадсан байдаг. Тухайн үед зарим шар сайт дуучин бүсгүйн шинэ харилцаа гурван сар хүрэхгүй байх вий гэдэгт ихэд санаа зовниж байв. Тэд анх далайн эрэгт үнсэлцэж байхдаа папарацчидын дуранд өртөж байсан бол үүний дараа Тайлорын эцэг эхтэй танилцаж, дараа нь Томын гэр бүлтэй танилцсан юм. Тэдний харилцаа хурдтай гүнзгийрч, шүтэн бишрэгчид нь тун удахгүй хуримын зар дуулгах нь хэмээн хүлээж суув. Гэвч Тайлор Томтой үерхэж эхлээд ердөө гурван сарын дараа ийнхүү салжээ.

ДУУЛГАХ СОНИН

Солонгос хоолны фестивалд саатаарай

Монгол, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ойг тохиолдуулан БНСУ-ын Элчин сайдын яамнаас энэ сарын 6-12-ны өдрүүдэд соёл, урлагийн үйл ажиллагааг зохион байгуулах гэж буй. "Солонгосын долоо хоног 2016" арга хэмжээ загварын шоуугаар нээлтээ хийсэн бол "Монгол орны байгалийн үзэсгэлэнт газрууд" гэрэл зургийн

үзэсгэлэнгээр үргэлжилж байгаа юм. Тэгвэл энэ үйл ажиллагааны хүрээнд өнөөдөр 17.00 цагт Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд Солонгос хоолны фестивал зохион байгуулагдах аж. Энэ үеэр солонгос хоолонд дуртай иргэд хямд үнээр дуртай хоолоо худалдан авч зооглох боломжтой гэнэ. Харин 19.00 цагт мөн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд Солонгосын 1988 оны

дүр төрхийг харуулсан олон ангит киноны дуу дуулсан дуучин Ким Чан Воны хамтлагийн тоглолт зохион байгуулагдах юм байна. Тиймээс Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд амттай хоол зооглонгоо алдартай дуучны урын сангаас шимтэн сонсч нэг үдшийг тухлан өнгөрүүлээрэй.

Монгол залуугийн шинэ уран бүтээл БНСУ-д хит болжээ

БНСУ-ын "Монтант" гэх найман өөр орны уран бүтээлчийг нэгтгэсэн урлагийн байгууллагад ажилладаг монгол залуу анхны уран бүтээлээ гаргажээ. Улмаар шинэ уран бүтээл нь хөгжмийн сайтуудад цацагдаж, өмнөд солонгосчуудыг байлдан дагуулж эхэлсэн байна. Түүний нэрийг


С.Гантоого гэдэг. Тэрбээр R&B, поп этник чиглэлээр дуулдаг бөгөөд "At the end of the World" гэх уран бүтээлээ гаргасан аж. Түүний дуу энэ сарын 6-наас эхлэн БНСУ-ын "www.melon.com", "www.bugs.com", "www.naver-music.com" зэрэг бүхий л сайтуудад гарч, хит чартуудын эхний наймд

эрэмбэлэгдэж эхэлсэн байна. Түүний "At the end of the World" дуу нь аливаа хүнд хэцүү, уйтгар гунигтай, хагацал зовлон учирсан ч гэсэн амьдралд бууж өгөлгүй бэрхшээлийг туулж, ямагт хүчтэй, тэвчээртэй, өөдрөг байхыг уриалсан утгатай аж.






Аадар багын анд Шэнгэлийнхээ дуудлагаар Дархан хотыг зорино. Гэвч тэнд Гантуг гэх түүний оорингэн найз нь эцгийнх нь остонтэй хуйвалдан урхи бэлдсэн байв. Аадарын эцэг хазгар Чука Мандалнарт эртний тооцоо байсныг Гантуг өөрт ашигтайгаар эргүүлж найзгаа золиосолж орхино. Гантугын багсаар хайртай бүсгүй дөнгөж мэндэлсэн бяцхан охиноосоо хагацсан Аадар ч бас ор сураггүй алга болно. Зургаан жилийн дараа гэнэт гарч ирсэн Аадар чухам юу хийж хэрхэх бол? Тэр амьдралаа эргүүлэн авч чадах болов уу?



Гарах хуй



16.09.30



Еврейн нолоотой гэр бүлээс гаралтай Бен-Хур-аас ромын иргэн хамгийн сайн найз нь урваж боол болгоно. Оргож эх орондоо ирээд өшөөгөө авна.



2016.8.26

Хэмгэдэх сүүлийн 15 жил 23 ажлаас халагджээ. Мул нь тэр цахилгааны инженер болох хүсэлтэй ч хувь тавилан тэрнийг хааш нь ч хамаагүй аваад шидчихдэг гэхэд болно. Сүүлийн удаа тэр ажлаасаа халагдсанаа эхнэртээ хэлсэнгүй тас нуужээ..